



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын харьяа зарим Татварын хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, нийт 225,702,807.20 (хоёр зуун хорин таван сая долоон зуун хоёр мянга найман зуун долоон төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 197,808,831.34 (нэг зуун ерэн долоон сая найман зуун найман мянга найман зуун гучин нэгэн төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 9 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн
310 дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа зарим Татварын хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглагтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)	Эзэмшигч байгууллагы н нэрс
1	Ландкрузер-80, 76-77 АРА, арал № HDJ810065130	1996/ 2010	197,0	31,000,000.00	24,465,653.00	6,534,347.00	0	6,540,000.00	1,635,000.00	Архангай аймгийн Татварын хэлтэс
2	Тсана, 13-83 УНЭ, арал № LGBF1AE068RO13552	2001/ 2007	210,0	44,252,807.20	44,252,807.20	0	0	1,000,000.00	250,000.00	Багахангай дүүргийн Татварын хэлтэс
3	Ландкрузер-80, 04-08 ГАА, арал№ HDJ810035502	1993/ 2010	231,0	28,000,000.00	28,000,000.00	0	0	1,500,000.00	375,000.00	Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс
4	Верна, 44-96 ХОА, арал№ КМНСГ41GP1U258935	2001/ 2011	173,0	7,500,000.00	7,500,000.00	0	0	500,000.00	125,000.00	Ховд аймагийн Татварын хэлтэс
5	Пилдэр, 44-95 ХОА, арал№ NZE1210105831	2002/ 2011	137,0	9,500,000.00	9,500,000.00	0	0	500,000.00	125,000.00	Ховд аймагийн Татварын хэлтэс
6	Старех, 58-30 СЭА, арал№ КМJJWWH7HP4U683728	2004/ 2011	151,0	20,000,000.00	18,499,936.00	1,500,064.00	0	1,600,000.00	400,000.00	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс

7	УАЗ-31512, 93-12 СБА, арал№ 80594694	2007/ 2007	289,0	15,950,000.00	15,950,000.00	15,950,000.00	0	0	500,000.00	125,000.00	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс
8	Аллион, 00-15 ОРО, арал№ NZT2405002884	2003/ 2011	158,0	15,000,000.00	11,364,815.63	3,635,184.37	0	3,700,000.00	925,000.00	Орхон аймгийн Татварын хэлтэс	
9	Х-трайл, 00-39 ОРО, арал№ JN11MANT31ZO102761	2012/ 2012	107,0	54,500,000.00	38,275,619.51	16,224,380.49	0	16,300,000.00	4,075,000.00	Орхон аймгийн Татварын хэлтэс	
	Нийт дүн			225,702,807.20 (хоёр зуун хорин таван сая долоон зуун хоёр мянга найман зуун долоон төгрөг хорин мөнгө)	197,808,831.34 (нэг зуун ерэн долоон сая найман зуун найман мянга гучин нэгэн төгрөг гучин дөрвөн мөнгө)	27,893,975.86 (хорин долоон сая найман зуун ерэн гурван мянга есөн зуун далан таван төгрөг наян зургаан мөнгө)		32,140,000.00 (гучин хоёр сая нэг зуун дөчин мянган)			